



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 12 сарын 16 өдөр

Дугаар 397

Улаанбаатар хот

Үнэт цаасыг нийтэд санал болгохыг
зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлээс хасах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.10, Компанийн тухай хуулийн 23 дугаар зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 408 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 6.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Баялаг налайх” ХК-ийн нийтэд санал болгон гаргасан нийт 311,872 /гурван зуун арван нэгэн мянга найман зуун далан хоёр/ ширхэг энгийн хувьцааг нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлээс хасахыг Үнэт цаасны газар /Б.Лхагвасүрэн/, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн бүртгэлээс хасахыг “ҮЦТХТ” ХХК /Ж.Байгалмаа/-д тус тус үүрэг болгосугай.


2. Хувьцаагаа компанид эргүүлэн авахыг шаардах эрх үүссэн хувьцаа эзэмшигчдийн эзэмшилд байгаа хувьцаанд оногдох ногдол хувийн мөнгийг нэгж хувьцаанд 249 /хоёр зуун дөчин есөн/ төгрөгөөр тооцон “ҮЦТХТ” ХХК-д гэрээ байгуулан төвлөрүүлж, хувьцаа эзэмшигчдийн шаардах эрхийг хэрэгжүүлэх нөхцөлөөр хангахыг “Баялаг налайх” ХК /Р.Гансүх/, “ҮЦТХТ” ХХК /Ж.Байгалмаа/-д тус тус үүрэг болгосугай.

3. Компанийн хэлбэрийг өөрчлөн хязгаарлагдмал хариуцлагатай компани болох шийдвэр гарсантай холбогдуулан өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдан авахыг шаардах эрхээ хэрэгжүүлээгүй хувьцаа эзэмшигч түүнд ногдох ногдол хувийн мөнгөн хөрөнгийг авалгүйгээр хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа эзэмшигчээр үлдэх хүсэлтийг хэдийд ч гаргаж болохыг дурдсугай.

4. Энэ тогтоолын 3-т заасан хүсэлт гаргасан хувьцаа эзэмшигчийг өөрчлөн байгуулагдаж байгаа хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа эзэмшигчээр бүртгэж авах үүргийг тухай бүр хэрэгжүүлэхийг “Баялаг налайх” ХК /Р.Гансүх/-д даалгасугай.

5. Энэ тогтоол батлагдсанаас хойш ажлын 10 хоногийн дотор Улсын бүртгэлийн ерөнхий газарт мэдээлэл хүргэх, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

F:\ajil 2019\Blank\Togtool.doc

000830